



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 01 өдөр

Дугаар

102

Улаанбаатар хот

Х.Өлзийжаргалыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Мэдээллийн технологи, сургалт сурталчилгаа, архив, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Х.Өлзийжаргал нь ажлаас чөлөөлөгдөх өөрийн хүсэлт гаргасан тул 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн чөлөөлсүгэй.

2. Х.Өлзийжаргалын ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:


Н.Насанжаргал

Ж.Баасанжав

Эрүүл мэнд, сайн дурын
даатгалын байцаагч-Ахлах
нягтлан бодогч
Үйлчлэгч

3. Х.Өлзийжаргалд ажлыг зохих журмын дагуу хүлээн авч, ажилласан хугацааны ээлжийн амралтын олговор болон санхүүгийн холбогдох бусад тооцоог хийж, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч (Н.Насанжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БАЯРТУЯА



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 01 өдөр

Дугаар 203.

Улаанбаатар хот

А.Мөнхцэцэгийг түр орлон гүйцэтгэгчээр
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487, “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491, 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Унаа хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/88 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. А.Мөнхцэцэгийг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Тэтгэвэр тэтгэмжийн байцаагчийн сул орон тоо нөхөгдөх хүртэл хугацаагаар уг албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.


2. А.Мөнхцэцэгийн ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулж, холбогдох тоног төхөөрөмж, бичиг баримтыг хүлээлгэн өгөхийг ажлын хэсэг (Н.Насанжаргал)-д даалгасугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Насанжаргал Эрүүл мэнд, сайн дурын даатгалын байцаагч-Ахлах нягтлан бодогч

Гишүүд: Ж.Баасанжав Үйлчлэгч

3. А.Мөнхцэцэгийн сарын үндсэн цалинг (ТЗ-8) 1200000 (Нэг сая хоёр зуу) төгрөгөөр тооцож, төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийг 3 хувиар, хоолны хөнгөлөлтийн хамт олгохыг Ахлах нягтлан бодогч (Н.Насанжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.БАЯРТУЯА



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 онь 02 сарын 14 өдөр

Дугаар

А/СЧ

Улаанбаатар хот

Н.Насанжаргалыг Ахлах нягтлан бодогчийн
албан тушаалаас чөлөөлж, ажилд
томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21, 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487, “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491, 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Унаа хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/88 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхэд асрах чөлөөтэй байсан Б.Удвал ажилдаа орох хүсэлт гаргасан тул Н.Насанжаргалыг 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн Ахлах нягтлан бодогчийн албан тушаалаас чөлөөлж, Орлого шимтгэл, сайн дурын даатгалын байцаагч няраваар томилон ажиллуулсугай.

2. Н.Насанжаргалын сарын үндсэн цалинг (ТЗ-8) 1200000 (Нэг сая хоёр зуу) төгрөгөөр тооцож, албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар, төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийг 24 хувиар тогтоож хоолны хөнгөлөлтийн хамт олгохыг Ахлах нягтлан бодогч (Б.Удвал)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (А.Мөнхцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БАЯРТУЯА



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 305

Улаанбаатар хот

Б.Удвалыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21, 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487, “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491, 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, 2012 оны Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хорооны 5 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Унаа хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/88 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Б.Удвал ажилдаа орох хүсэлт гаргасан тул 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн Ахлах нягтлан бодогчийн албан тушаалд томилон ажиллуулсугай.

2. Б.Удвалын ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулж, холбогдох тоног төхөөрөмж, бичиг баримтыг хүлээлгэн өгөхийг ажлын хэсэг (А.Мөнхцэцэг)-т даалгасугай.

Ажлын хэсгийн ахлагч: А.Мөнхцэцэг Тэтгэвэр тэтгэмжийн байцаагч,
Хүний нөөцийн мэргэжилтэн

Гишүүд: Ж.Баасанжав Үйлчлэгч

3. Б.Удвалын сарын үндсэн цалинг (ТЗ-7) 1320000 (Нэг сая гурван зуун хорин мянга) төгрөгөөр тооцож, албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар, төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийг 13 хувиар, эрх бүхий албан тушаалтны нэмэгдлийг 40 хувиар тогтоож хоолны хөнгөлөлтийн хамт олгохыг Ахлах нягтлан бодогч (Б.Удвал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.БАЯРТУЯА



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 01 өдөр



Дугаар 7/06

Улаанбаатар хот

**А.Мөнхцэцэгийг албан тушаал
түр орлон гүйцэтгүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 43 дугаар зүйлийн 43.3.3, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.2, 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487, 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. Тэтгэвэр, тэтгэмжийн байцаагч, хүний нөөцийн мэргэжилтэн А.Мөнхцэцэгийг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Мэдээллийн технологи, сургалт сурталчилгаа, архив дотоод асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог нөхөгдөх хүртэл уг албан тушаалыг түр орлон гүйцэтгүүлсүгэй.
2. А.Мөнхцэцэгт албан тушаал түр орлон гүйцэтгэсний цалинг үндсэн цалин болох (ТЗ-8) 1200000 төгрөгийн 40 хувиар тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч (Б.Удвал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Б.БАЯРТУЯА
ДАРГА 



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 3/04

Улаанбаатар хот

Н.Баярсайханыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 50 дугаар зүйлийн 50.1.5, Засгийн газрын 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Н.Баярсайханыг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн жолоочоор томилон ажиллуулсугай.

2. Н.Баярсайханы ажил хүлээлцэх комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын ахлагч:

Б.Удвал

Ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Н.Насанжаргал

Орлого шимтгэл, сайн дурын даатгал, хяналтын улсын байцаагч, хөрөнгө хариуцсан ажилтан

А.Мөнхцэцэг

Тэтгэвэр, тэтгэмжийн байцаагч хүний нөөцийн мэргэжилтэн

3. Н.Баярсайхантай хөдөлмөрийн гэрээг байгуулж, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (А.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Н.Баярсайханы сарын үндсэн цалинг (ТҮ-3) 865000 (Найман зуун жаран тав) төгрөгөөр тооцож олгохыг Ахлах нягтлан бодогч (Б.Удвал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.БАЯРТУЯА



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар

Б/08

Улаанбаатар хот

Н.Насанжаргалыг албан тушаалаас чөлөөлж,
өөр албан тушаалд томилох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 2019 оны “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам батлах тухай” 21, 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487, “Журамд өөрчлөлт оруулах тухай” 491, 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх сэргээх, баталгаажуулах тухай” А/226 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Унаа хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/88 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Н.Насанжаргал нь Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх сэргээх шалгалтанд тэнцэж, урьдчилсан мэдүүлэг хянуулж ашиг сонирхлын зөрчил үүссэн нөхцөл байдал тогтоогдоогүй тул 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн Орлого шимтгэл, сайн дурын даатгал, хяналтын улсын байцаагч-хөрөнгө хариуцсан ажилтнаар томилон ажиллуулсугай.

2. Н.Насанжаргалын сарын үндсэн цалинг (ТЗ-7) 1320000 (Нэг сая гурван зуун хорин мянга) төгрөгөөр тооцож, албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг 24 хувиар, төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийг 24 хувиар тогтоож, хоолны хөнгөлөлтийн хамт олгохыг Ахлах нягтлан бодогч (Б.Удвал)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2024 оны Б/04 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БАЯРТУЯА



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар

Б/09

Улаанбаатар хот


Б.Удвалыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх сэргээх, баталгаажуулах тухай” А/226 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Б.Удвал нь Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх сэргээх шалгалтанд тэнцэж, урьдчилсан мэдүүлэг хянуулж ашиг сонирхлын зөрчил үүссэн нөхцөл байдал тогтоогдоогүй тул 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн Ахлах мэргэжилтэн, улсын байцаагчаар томилж, урьд авч байсан цалин хөлс болон бусад нэмэгдлүүдийг хэвээр олгосугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (А.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БАЯРТУЯА



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 7/13

Улаанбаатар хот

Албан хаагчдын цалинг шинэчлэн
тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь хэсэг, 2024 оны “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 3,11 дүгээр хавсралт, “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн албан хаагчдын цалин шинэчлэн батлагдсантай холбогдуулан төрийн захиргааны албан хаагчдын цалинг нэгдүгээр, төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Албан хаагчдын шинэчлэн тогтоосон цалин болон орон нутагт ажилласны нэмэгдлийг 2024.04.01-нээс тооцож, бусад нэмэгдлийг хэвээр үлдээж, хоолны хөнгөлөлтийн хамт олгохыг Ахлах мэргэжилтэн (Б.Удвал)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан хэлтсийн даргын 2023 оны Б/13, 2024 оны Б/03, Б/05, Б/07, Б/08 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БАЯРТУЯА

Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн
дарлын 2024 оны 04 дүгээр сарын 08 өдрийн
тоот тушаалын хоёрдугаар хавсралт



Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин түүний нэмэгдэл

д/д	Овог, нэр	Албан тушаал	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Үндсэн цалин
1	Ж.Баасанжав	Үйлчлэгч	ТҮ-1	900 000
2	Н.Баярсайхан	Жолооч	ТҮ-3	992 000

Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газрын
даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-дрийн
тоот тушаалын нэгдүгээр хавсралт



Төрийн захиргааны албан хаагчдын цалин түүний нэмэгдэл

д/д	Овог, нэр	Албан тушаал	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Үндсэн цалин	Орон нутагт ажилласны нэмэгдэл
1	Б.Удвал	Ахлах мэргэжилтэн, улсын байцаагч	T3-7	1 452 000	20
2	А.Мөнхцэцэг	Тэтгэвэр, тэтгэмжийн байцаагч-хүний нөөцийн мэргэжилтэн, мэдээллийн технологи, сургалт сурталчилгаа, архив, дотоод ажил хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	T3-8	1 320 000	20
3	Н.Насанжаргал	Орлого шимтгэл, сайн дурын даатгал, хяналтын улсын байцаагч-хөрөнгө хариуцсан ажилтан	T3-7	1 452 000	20



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 8/16

Улаанбаатар хот

Ж.Баасанжавыг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Үйлчлэгч Ж.Баасанжав нь ажлаас чөлөөлөгдөх өөрийн хүсэлт гаргасан тул 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн чөлөөлсүгэй.

2. Ж.Баасанжавын ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Б.Удвал
Н.Насанжаргал

Ахлах мэргэжилтэн
Орлого шимтгэл, сайн дурын
даатгал, хяналт, шалгалтын
байцаагч, хөрөнгө хариуцсан
ажилтан

А.Мөнхцэцэг

Тэтгэвэр, тэтгэмжийн байцаагч,
хүний нөөцийн мэргэжилтэн

3. Ж.Баасанжавын ажлыг зохих журмын дагуу хүлээн авч, ажилласан хугацааны ээлжийн амралтын олговор болон санхүүгийн холбогдох бусад тооцоог хийхийг Ахлах мэргэжилтэн (Б.Удвал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.БАЯРТУЯА



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 5/18.

Улаанбаатар хот

Г.Бадамхандыг ажилд түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 5.1.2, Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт, “Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 84 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт, “Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай” 82 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны “Унаа хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/88 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Г.Бадамхандыг бичиг хэргийн ажилтнаар 2024 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн түр томилон ажиллуулсугай.

2. Г.Бадамхандын ажил хүлээлцэх комиссыг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын ахлагч:

Б.Удвал

Ахлах нягтлан бодогч

Гишүүд:

Н.Насанжаргал

Орлого шимтгэл, сайн дурын

даатгал, хяналтын улсын

байцаагч, хөрөнгө хариуцсан

ажилтан

А.Мөнхцэцэг

Тэтгэвэр, тэтгэмжийн байцаагч

хүний нөөцийн мэргэжилтэн

3. Г.Бадамхандтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн (А.Мөнхцэцэг)-д үүрэг болгосугай.

4. Г.Бадамхандын сарын үндсэн цалинг (ТҮМ-3) 1210000 (Нэг сая хоёр зуун арван мянга) төгрөгөөр, орон нутагт ажилласны нэмэгдэл цалинг үндсэн цалингийн 20 хувиар тус тус тооцож, хоолны хөнгөлөлтийн хамт олгохыг Ахлах нягтлан бодогч (Б.Удвал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.БАЯРТУЯА



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 19 өдөр

Дугаар Б/19.

Улаанбаатар хот

**Албан хаагчдад хагас жилийн
үр дүнгийн урамшуулал олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3 дугаар хавсралтын 1.2.2, 2.2, 2.3 дахь хэсэг, 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 6.5, 6.6.1.б, 6.6.2.в, 2023 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 442 дугаар тогтоолын 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилтан, албан хаагчдын 2024 оны 1, 2 дугаар улирлын ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн ёс зүйн зөрчил гаргаагүй хавсралтад дурьдсан албан хаагчдад үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосугай.
2. Урамшуулалд зарцуулагдах 3247200 (Гурван сая хоёр зуун дөчин долоон мянга хоёр зуу) төгрөгийг үр дүнгийн урамшууллын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Б.Удвал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.БАЯРТУЯА

Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын
газрын даргын 20... оны... сарын... өдрийн
... дүгээр тушаалын хавсралт



Үр дүнгийн урамшуулал олгох албан хаагчдын нэрс

д/д	Овог, нэр	Үндсэн цалин	1-р улирлын урамшуулал олгох хувь	2-р улирлын урамшуулал олгох хувь	Нийт дүн
1	Б.Удвал	1452000	35	50	1234200
2	Н.Насанжаргал	1452000	35	40	1089000
3	А.Мөнхцэцэг	1320000	30	40	924000
Нийт					3247200